**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 30 өдөр | Дугаар 782 | Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 5 нэрийн, нийт 27,418,729,761.00 (хорин долоон тэрбум дөрвөн зуун арван найман сая долоон зуун хорин есөн мянга долоон зуун жаран нэг) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх, эзэмшигчийг тогтоох;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132003148

32-г huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
722 дугаар тогтоолын хавсралт

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Төсөл арга хэмжээний нэр | Ашиглалтад орсон он | Гүйцэтгэгчийн нэр | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн | Орон нутгийн өмчид бүртгэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлын эхлэл /Архангай/ | 2023.12.20 | Саруул харгуй ХХК | 5,590,844,334.00 | Архангай аймгийн ЗДТГ (ОНӨГ) |
| 2 | Сумын төвийн авто зам, 7 км /Архангай, Өндөр-Улаан сум/ | 2023.12.21 | Саруул харгуй ХХК | 5,713,114,400.00 | |
| 3 | Тоорцог толгойнтөмөр бетон гүүр, 169 у/м /БӨ,Бугат сум/ | 2023.09.08 | Жол ХХК | 5,789,865,886.00 | Баян-Өлгий аймгийн ЗДТГ (ОНӨГ) |
| 4 | ХО, Жаргалант, Баатархайрхан, Бичиг баг хайрган замын засвар | 2024.11.05 | Кеналхан ХХК | 868,044,069.00 | Ховд аймгийнЗДТГ (ОНӨГ) |
| 5 | Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км /Ховд аймаг, Мөст сум/ | 2020.07.15 | Хотгор зам ХХК | 9,456,861,072.00 | |
| | Нийт дүн | | | 27,418,729,761.00 (хорин долоон тэрбум дөрвөн зуун арван найман сая долоон зуун хорин есөн мянга долоон зуун жаран нэг) | |